

Төсөл

*Мал эмнэлгийн ерөнхий газрын 2018
оны . . . дугаар сарынны/ий
өдрийн дугаар тушаалын . . хавсралт*

ЛАБОРАТОРИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, нийтийн хэрэгцээнд нийлүүлэхэд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь заалтыг үндэслэн лаборатори шинжилгээ хийж, магадлан шинжилгээний гэрчилгээ олгоход энэхүү зааврыг дагаж мөрдөнө.
- 1.2 Энэхүү зааврыг мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд магадлан шинжилгээ хийх, аймаг, нийслэлийн хүнсний зах, худалдааны төв, үйлдвэрийн дэргэдэх лабораторийн шинжээч эмч болон хяналтын улсын байцаагч, иргэн, хуулийн этгээд, дагаж мөрдөнө.

Хоёр. Лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний нэр төрөл

- 2.1. Лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээг (*цаашид магадлан шинжилгээний гэрчилгээ гэх*) зөвхөн тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь ариун цэврийн магадлан шинжилгээний дүнгээр аюулгүй байдлын үзүүлэлт нь стандартын шаардлага хангасан болохыг тодорхойлох зорилгоор хэрэглэнэ.
- 2.2. Мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори нь дараах 4 төрлийн гэрчилгээ олгоно. Үүнд:
 - 2.2.1 Мах, махан бүтээгдэхүүний магадлан шинжилгээний гэрчилгээ (**Хавсралт-01**)
 - 2.2.2 Сүү, сүүн бүтээгдэхүүний магадлан шинжилгээний гэрчилгээ (**Хавсралт-02**)
 - 2.2.3 Өндөгний магадлан шинжилгээний гэрчилгээ (**Хавсралт-03**)
 - 2.2.4 Зөгийн балны магадлан шинжилгээний гэрчилгээ (**Хавсралт-04**)
- 2.3. Магадлан шинжилгээний гэрчилгээний хуудас нь улсын хэмжээнд нэгдсэн код, дугаартай хэвлэмэл маягт байх ба нэг хорон хувьтай хуудас байна.
- 2.4 Энэхүү зааврын хавсралт 2.2-д баталсан магадлан шинжилгээний гэрчилгээ нь мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд олгох зориулалтай бөгөөд Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр байна.

Гурав. Гэрчилгээг хэвлүүлэх, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих

- 3.1. Мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан загварын дагуу гэрчилгээний хуудсыг нэгдсэн код, тусгай нууцлалтай хэвлүүлэн дугаарлана.
- 3.2. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар гэрчилгээг холбогдох мал эмнэлгийн лабораторид нэгдсэн бүртгэлтэйгээр хуваарилан хүргүүлнэ. Мал эмнэлгийн ерөнхий газрын зөвшөөрч хэвлүүлж, хуваарилснаас бусад гэрчилгээг хүчингүйд тооцно.
- 3.3. Магадлан шинжилгээний гэрчилгээний хуваарилалт, зарцуулалтад мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавих ба холбогдох мэдээг нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ.

Дөрөв. Гэрчилгээ бичиж олгох

- 4.1 Хадгалалт, тээвэрлэлтийн явцад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гадна байдалд өөрчлөлт орсон, бохирдсон болох нь тогтоогдсон бол эрх бүхий лаборатори сорьц авч магадлан шинжилгээ хийнэ.
- 4.2 “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 27.5 хэсэгт заасны дагуу шинжилгээ хийсэн лаборатори магадлан шинжилгээний гэрчилгээ олгоно.
- 4.3 Гэрчилгээ олгохдоо үзлэг, шинжилгээнд мэдрэхүйн үзлэгээс гадна лабораторийн шинжилгээг заавал хийсэн байх ба үзлэг шинжилгээний үр дүнг тодорхой бичсэн байна.
- 4.4 Лабораторийн шинжилгээ хийхгүйгээр зөвхөн мэдрэхүйн үзлэг хийж магадлан шинжилгээний гэрчилгээ олгохгүй бөгөөд уг гэрчилгээ хүчингүйд тооцогдоно.
- 4.5 Орон нутгаас олгосон мал эмнэлгийн гэрчилгээ, тодорхойлолтыг хураан авахгүй бөгөөд бүртгэл хөтлөн шинжилгээ хийсний дараа магадлан шинжилгээний гэрчилгээг давхардуулан олгоно.
- 4.6 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн худалдан авагчид орон нутгаас олгосон гэрчилгээ дагалдах боломжгүй, нэг гэрчилгээнд бичигдсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг 2 буюу түүнээс дээш этгээд худалдан авсан тохиолдолд лабораторийн шинжилгээ хийж магадлан шинжилгээний гэрчилгээг дангаар нь олгож болно.
- 4.7 Орон нутгаас ирсэн мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгоно.
- 4.8 Магадлан шинжилгээний гэрчилгээг үзлэг, шинжилгээний дүнг үндэслэн олгох ба тухайн түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээ, тодорхойлолтын дугаарыг заавал бичнэ.
- 4.9 Хувийн хэрэгцээний хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд иргэн өөрөө хүсээгүй бол магадлан шинжилгээний гэрчилгээ олгохгүй бөгөөд “Мал эмнэлэг-ариун цэвэр, гарал үүслийн тодорхойлолт” заавал дагалдуулна.
- 4.10 “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.7.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори сорьцонд шинжилгээ хийж магадлан шинжилгээний дүгнэлт, гэрээт мал эмнэлгийн нэгж итгэмжлэгдсэн лабораторитой бол магадлан шинжилгээний гэрчилгээ олгоно.
- 4.11 “Гэрчилгээний код” хэсэгт мал эмнэлгийн магадлан шинжилгээ хийх баталгааны тэмдэгт хэрэглэх журмын хавсралтаар батлагдсан кодыг бичнэ.
- 4.12 “Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ” хэсэгт түүний нэр, тоо хэмжээг хэмжих нэгжээр нь тодорхой, үнэн зөв бичнэ. Гэрчилгээний 2.2.1-д далайн амьтны буюу далайн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бичнэ.
- 4.13 Орон нутгаас олгосон гэрчилгээний дугаар хэсэгт мал эмнэлгийн гэрчилгээний дугаарыг гаргацтай тод бичнэ.
- 4.14 “Бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, бэлтгэсэн газар, гарал үүсэл” хэсэгт мал эмнэлгийн гэрчилгээнд бичигдсэн бэлтгэсэн газар, эзний нэр, утас зэргийг тодорхой бичнэ.
- 4.15 “Үзлэг, шинжилгээ” хэсэгт мэдрэхүйн үзлэгийн үнэлгээг бичихээс гадна лабораторийн шинжилгээг заавал хийх бөгөөд дүнг стандарт тэмдэглэгээ оруулан бичнэ.
- 4.16 Хүснэгтэнд үзлэг, шинжилгээний дүнг итгэмжлэл, стандартын дагуу олон улсын нэгж, хэмжээг бичих, “шаардлага хангасан” болохыг, “хангаагүйг” **Х**-ээр тэмдэглэн хүснэгтийг бөглөж бичнэ.
- 4.17 “Үзлэг, шинжилгээний дүн” хэсэгт лабораторийн итгэмжлэлийн хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж бичнэ.
- 4.18 “Дээрх бичигдсэн зүйл үнэн болохыг батлан гэрчилгээ олгосон” хэсгийг үнэн зөв гаргацтай бичиж “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”-ын дагуу олгогдсон код бүхий баталгааны гурвалжин тэмдэг дарж баталгаажуулна.

Тав. Магадлан шинжилгээний гэрчилгээний цахим хэлбэр

- 5.1 Магадлан шинжилгээний гэрчилгээний загвар нь энэхүү заавраар баталсан “Магадлан шинжилгээний гэрчилгээ”-ний загварт тусгагдсан асуумжтай байна.
- 5.2 Магадлан шинжилгээний гэрчилгээний цахим гэрчилгээг орон нутгаас илгээсэн мэдээллийн хамт лабораторийн шинжээч эмч тоон гарын үсгээр баталгаажуулж гэрчилгээ хэвлэгч машин бүхий эрх бүхий этгээдэд илгээнэ.
- 5.3 Хэвлэх эрх бүхий этгээд шинжээчээс илгээгдсэн магадлан шинжилгээний гэрчилгээний дагалдах хувилбарыг хэвлэх ба борлуулагч этгээдэд олгоно.
- 5.4 Эрх бүхий этгээд гэдэг нь тухайн лабораторид цахимаар тоон гарын үсгээр баталгаажсан магадлан шинжилгээний гэрчилгээ хэвлэх эрх авсан шинжээч эмч байна.
- 5.5 Цахим гэрчилгээ олгохоор тоон гарын үсгээр баталгаажуулалт хийсэн шинжээч эмч шилжилт хөдөлгөөн хийсэн мал амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мэдээллийн нэгдсэн цахим сангийн мэдээллийн санд хасалт хийж бүртгэнэ.
- 5.6 Гэрчилгээ олгосон шинжээч эмч шилжилт хөдөлгөөн хийсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах цэг, дамжин өнгөрөх хяналтын цэг, тээвэрлэх маршрутыг оруулан төв серверт илгээнэ.
- 5.7 Дамжин өнгөрөх мал эмнэлгийн хяналтын цэгийн улсын байцаагч тээвэрлэж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн гэрчилгээ олгосон орон нутгаас илгээгдсэн мэдээлэлтэй тулгаж зөрчилгүй бол хяналт шалгалт хийсэн мэдээллийг нэгдсэн цахим санд оруулж тоон гарын үсгээр баталгаажуулна.
- 5.8 Мал эмнэлгийн хяналтын цэгийн байцаагчийн хяналт шалгалтаар илгээгдсэн мэдээлэлтэй зөрүүтэй нөхцөлд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27.7 дахь хэсэгт заасан арга хэмжээ авна.
- 5.9 Тээвэрлэгч этгээд орон нутгаас хэвлэж өгсөн цахим гэрчилгээг үрэгдүүлсэн бол хяналтын цэгийн байцаагч төв серверт мэдээлэл илгээсэн улсын байцаагчтай холбогдож үнэн бодит байдлыг нягтлан шалгаж анх олгосон этгээдийн цахим зөвшөөрлөөр гэрчилгээг нөхөн олгож болно.

Зургаа. Магадлан шинжилгээний гэрчилгээний бүртгэл, мэдээлэл

- 6.1 Магадлан шинжилгээний гэрчилгээ олгосон мал амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд холбогдох мэдээллийг лабораториос олгосон гэрчилгээний асуумжаар сум, дүүрэг дэх тасгийн болон сүлжээ лабораторийн тархвар зүйч мэдээллийн нэгдсэн цахим санд бүртгэнэ.
- 6.2 Бүртгэлийг маламьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, үзлэг шинжилгээний үр дүнгээр мэдээллийн сан үүсгэн бүртгэсэн байна.
- 6.3 Магадлан шинжилгээний гэрчилгээ олгосон мал амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд холбогдох мэдээ тайланг тухайн лаборатори харъяа сум дүүрэг, сүлжээ лабораторид Мал эмнэлгийн ерөнхий газрын баталсан маягтын дагуу, хугацаанд нь хүргүүлнэ.

Долоо. Гэрчилгээний хугацаа, баталгаа

- 7.1. Магадлан шинжилгээний гэрчилгээ нь “Мал эмнэлгийн гэрчилгээ”, түүний “Мал эмнэлэг-ариун цэвэр, гарал үүслийн тодорхойлолт”-ын дагалдах хувьтай хамт хүчинтэй байна.
- 7.2. Магадлан шинжилгээний гэрчилгээ нь тухайн гэрчилгээ олгосон өдрөөс хойш доорх хугацаанд хүчинтэй байна. Үүнд:
 - 7.2.1. Мал амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд: Дулааны улиралд тохирох хэмд 7 (5) хоног хүртэл (4-р сарын 15-аас 10-р сарын 15),
 - 7.2.2. Хүйтэн сэрүүний улиралд тохирох хэмд 14 (10) хоног хүртэл (10-р сарын 15-аас 4-р сарын 15) байна.

7.3. Гэрчилгээнд бичигдсэн зүйлийн үнэн зөв бодит байдлыг тодорхойлж гэрчилгээ олгосон шинжээч эмч хуулийн өмнө бүрэн хариуцна.

-----oOo-----

Хавсралт- 01

УМЭЕГ маягт №

КОД [][][][][][][]

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАГАДЛИАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ № ...

- 1.Худалдан борлуулагч (овог нэр, утас)
2. Худалдааны төвийн нэр
3. Лангууны дугаар
4. Мах, махан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ
5. Бэлтгэсэн, үйлдвэрлэсэн газар.....
6. Орон нутгаас олгосон гэрчилгээний №

7. Үзлэг, шинжилгээ:

а). Мэдрэхүйн үзлэгээр:

Үзүүлэлт	Үнэлгээ	Лавлах хэмжээ	Шаардлага хангах эсэх, х/v
- өнгө			
- үнэр			
- биелэг байдал			

б). Лабораторийн шинжилгээ:

Үзүүлэлт	Шинжилгээний дүн	Лавлах	Хангах эсэх, х/v
- рН			
-шинэлэг байдал			
-махны байдал (өвчтэй,үхсэн, төрөл)			
-финноз/трихнелл			
-нянгийн бохирдол			
-мөөгөнцөр			
- эмийн үлдэгдэл			
- хүнд металл			
- бусад			

8. Үзлэг, шинжилгээний дүн:.....

9. Үзлэг, шинжилгээ хийж гэрчилгээ олгосон
-ийн шинжлэгч эмч: /...../
(тэмдэг, гарын үсэг, нэр, гаргацтай бичих)

10. Хүчинтэй хугацаа:

20..... оны сарын өдрөөс ... сарын ... өдрийг дуустал **төлбөрийн хуудасны хамт** хүчинтэй.

20.....оны.....сарын.....өдөр

Хавсралт- 02

УМЭЕГ маягт №

КОД [][][][][][][]

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МАГАДЛИАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ № ...

- 1.Худалдан борлуулагч (овог нэр, утас)
2. Худалдааны төвийн нэр
3. Лангууны дугаар
4. Сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ
5. Бэлтгэсэн, үйлдвэрлэсэн газар.....
6. Орон нутгаас олгосон гэрчилгээний №

7. Үзлэг, шинжилгээ:

а). Мэдрэхүйн үзлэгээр:

Үзүүлэлт	Үнэлгээ	Лавлах хэмжээ	Шаардлага хангах эсэх, х/v
- өнгө, үнэр			
- биелэг байдал			

б). Лабораторийн шинжилгээ:

Үзүүлэлт	Шинжилгээний дүн	Лавлах	Зөвшөөрөх эсэх, х/v
- хүчиллэг			
- шүвтэр			
- нягтрал			
- хольц			
- тослог			
- нянгийн бохирдол			
- бруцеллез			
- дэлэнгийн үрэвсэл			
- эмийн үлдэгдэл			
- хүнд металл			
- бусад			

8. Үзлэг, шинжилгээний дүн:.....

9. Үзлэг, шинжилгээ хийж гэрчилгээ олгосон
-ийн шинжлэгч эмч /...../
(тэмдэг, гарын үсэг, нэр, гаргацтай бичих)

10. Хүчинтэй хугацаа:

20..... оны сарын өдрөөс ... сарын ... өдрийг дуустал **төлбөрийн хуудасны хамт** хүчинтэй.

20....оны.....сарын.....өдөр

КОД

--	--	--	--	--	--

ӨНДӨГНИЙ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ № . . .

- 1.Худалдан борлуулагч (овог нэр, утас)
2. Худалдааны төвийн нэр
3. Лангууны дугаар
4. Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ
5. Бүтээгдэхүүний гарал үүсэл

6.Үзлэг шинжилгээ:

а). Мэдрэхүйн үзлэгээр:

Үзүүлэлт	Үнэлгээ	Лавлах хэмжээ	Шаардлага хангах эсэх, х/ү
-бүрэн бүтэн(ШБ)			
- өнгө, үнэр			
- хэлбэр			
-гадна бохирдолт			

б). Лабораторийн шинжилгээ:

Үзүүлэлт	Дүн	Лавлах	Зөвшөөрөгдөх эсэх, х/ү
-хийн зай хэмжээ			
-хийн зай хөдөлгөөн			
- шар уургийн байдал			
- нянгийн бохирдол			

7. Үзлэг, шинжилгээний дүн.....

8. Үзлэг, шинжилгээ хийж гэрчилгээ олгосон:

- ийн шинжлэгч эмч/...../

(тэмдэг, гарын үсэг, нэр, гаргацтай бичих)

9. Хүчинтэй хугацаа:20.... оны сарын өдрөөс ... сарын ... өдрийг дуустал **төлбөрийн хуудасны хамт** хүчинтэй.

20....оны.....сарын.....өдөр

КОД

--	--	--	--	--	--

ЗОГИЙН БАЛНЫ МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ГЭРЧИЛГЭЭ № . . .

- 1.Худалдан борлуулагч (овог нэр, утас)
2. Худалдааны төвийн нэр
3. Лангууны дугаар
4. Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ
5. Бүтээгдэхүүний гарал үүсэл

6.Үзлэг, шинжилгээ:

а). Мэдрэхүйн үзлэгээр:

Үзүүлэлт	Үнэлгээ	Лавлах хэмжээ	Шаардлага хангах эсэх, х/ү
- өнгө			
- үнэр, амт			
- исэлдэлт			
- биелэг байдал			
-механик хольц			

б). Лабораторийн шинжилгээ:

Үзүүлэлт	Дүн	Лавлах	Зөвшөөрөгдөх эсэх, х/ү
- чийглэг			
- хүчиллэг			
- инвертийн сахар			
- нянгийн бохирдол			
- эмийн үлдэгдэл			
- хүнд металл			

7. Үзлэг, шинжилгээний дүн.....

8. Үзлэг, шинжилгээ хийж гэрчилгээ олгосон:

- ийн шинжлэгч эмч/...../

(тэмдэг, гарын үсэг, нэр, гаргацтай бичих)

9. Хүчинтэй хугацаа:20.... оны сарын өдрөөс ... сарын ... өдрийг дуустал **төлбөрийн хуудасны хамт** хүчинтэй.

20....оны.....сарын.....өдөр